

**Петро Матад Лимитед
("Петро Матад" эсвэл "Компани" гэх)**

Петро Матад Компани нь Давсан Толгой-8 цооногийг ("ДТ-8" гэх) 1,850 метрийн гүнд хувирмал чулуулаг хүртэл өрөмдөж дуусгасныг мэдэгдэж байна.

Өрөмдлөгийн явцад 1,670 метрийн гүнээс эхлэн Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсэгт (Өвгөн голын эртний хөндий) 127 метр зузаан нэвтэрсэн. Цооногийн хэмжилтээр хийн муруйн үзүүлэлт Дээд Цагаанцавын Формацийн дээр орших Доод Зүүнбаянгийн тусгаарлагч давхаргад тогтвортой нэмэгдэж улмаар энэ нь Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсэгт үргэлжилсэн байна. 1,714-1,720 метрийн хооронд Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн элсэн чулууны бүсэд амьд тосны илэрц ажиглагдсан бөгөөд эндээс гарсан үйрмэг нь толборхог флюоресценц, цэнхэрдүү-цагаанаас шар-алтан шаргал өнгөтэй байгаа нь нүүрсустөрөгч байгааг илтгэнэ. Петрофизикийн эхний шинжилгээгээр Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсэгт дунджаар 18.5 хувийн нүх сүвшилтэй 8.5 метрийн цэвэр зузаан бүхий тост үе байгааг тогтоосон.

ДТ-8 цооногийн өрөмдлөгийн үндсэн зорилго нь Доод Цагаанцавын Формацийг судлахад чиглээгүй байсан бөгөөд тус цооногийн өрөмдлөгөөр Доод Цагаанцавын Формаци илрээгүй нь элэгдэл, хагаралтай холбоотой байх магадлалтай юм. 1,797 метрийн гүнээс цооногийн нийт гүн хүртэлхи хувирмал суурь чулуун хэсгийг өрөмдсөн.

Бид ДТ-8 цооногийг Өвгөн голын эртний хөндийд илэрсэн элсэн чулууны үе нь зэргэлдээх XIX талбайд өрөмдсөн Дачин компанийн 19-62 дугаар цооногт илэрсэн олборлолт хийж байгаа элсэн чулууны үеэс манай ДТ-5 цооногт илэрсэн нүүрс-устөрөгчөөр ханасан нимгэн элсэн чулууны үе рүү давхаргазүйн хувьд нимгэрч байгаа эсэхийг шалгах зорилгоор өрөмдсөн. Улмаар ДТ-5 цооногийн анхны тайлалыг дахин хянаж үзсэний үр дүнд тус цооногт давхаргазүйн хураагуур байгааг тогтоолоо. Бид 2011 оны 06 дугаар сарын 08-нд ДТ-5 цооногт 3 метрийн тооцоолсон цэвэр зузаан бүхий тост үе Доод Цагаанцавын Формацийн дээд хэсэгт, 1,707 метрийн гүнд байгааг мэдээлж байсан. Хурдын каротажийн бичиглэлийг 3 хэмжээст сейсмийн тайлалтай нэгтгэсэн үр дүнгээр энэхүү тост үе бүхэлдээ Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн эртний голын хөндийн ёроолоор байгааг харуулж байна.

ДТ-8 цооногийн өрөмдлөг, бэхэлгээний яндан суулгалт, цементлэх ажлууд бүрэн дууссан бөгөөд өрмийн цамхагийг шинээр өрөмдөх Давсан Толгой-9 ("ДТ-9" гэх) цооногийн байрлал руу нүүлгэж байна.

ДТ-9 цооног нь XX талбайн Давсан Толгойд орших хэтийн төлөв бүхий талбайдыг үнэлэх өрөмдлөгийн хөтөлбөрийн үргэлжлэл юм. ДТ-9 цооногийг Доод Цагаанцавын агуулагч давхаргыг судлах зорилгоор ДТ-4 цооноогоос урагш 2.5 км зайд, мөн цооногийн түвшингээс дээш 220 метрт өрөмдөнө. ДТ-4 цооногийн Доод Цагаанцавын Формациас авсан чөмөг дээжээс тосны ханалт илэрсэн билээ. ДТ-9 цооног нь Өвгөн голын эртний хөндийн нүүрсустөрөгч хуримтуулагч системийн баруун талд орших хэтийн төлөв сайтай "Шороо", "Төмөр" болон "Гал" зэрэг талбайнуудад ялгасан Доод Цагаанцавын Формацийн хэд хэдэн байрлалуудын нэг юм. Бид Давсан Толгойн 3 хэмжээст сейсмийн судалгааны дахин боловсруулсан үр дүнг ашиглан эдгээр Доод Цагаанцавын хэтийн төлөв сайтай талбайнуудыг дахин тайлсан юм.

Петро Матанд Компани цооногийн үйлчилгээний цамхаг, тоног төхөөрөмжийг Давсан Толгой руу нүүлгэх ажил дууссаныг мэдэгдэж байна. ДТ-1 цооногийн туршилтын ажлыг

2011 оны 08 дугаар сарын 01-нд эхлүүлсэн. ДТ-1 цооногт хийх туршилтаар ирэх долоо хоногт Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн тусдаа зургаан бүсийг тус бүрт нь дараалалаар нь шалгахар төлөвлөж байна.

ДТ-1 цооногийн туршилтын дараа өрмийн цамхаг, тоног төхөөрөмжийг бусад цооногууд руу нүүлгэнэ. Өвгөн голын эртний хөндийн агуулагч давхаргад өрөмдсөн ДТ-2, ДТ-5, ДТ-7, ДТ-8, Доод Цагаанцавын Формацийн агуулагч давхаргад өрөмдсөн ДТ-3, ДТ-4 болон Дээд Зүүнбаянгийн Формацийн агуулагч давхаргад нэвтэрсэн ДТ-3 цооногуудад туршилтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Петро Матад Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй өрөмдлөгийн үр дүнг дүгнэж хэлэхдээ “Бид ДТ-8 цооногийн өрөмдлөгөөр Өвгөн голын эртний хөндийд газрын тос байгааг баталсандаа баяртай байна. Цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа хайгуулын ажлыг цооногийн туршилтын хөтөлбөртэй зэрэгцүүлэх нь Матад ХХ талбайн цаашдын үнэлгээ, судалгаанд маш эерэг үр дүн үзүүлэх болно” гэлээ.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100